

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ДОПИНГИЙН ЭСРЭГ БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.12.30

Улаанбаатар хот

Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага нь тайлангийн хугацаанд Спортод допинг хэрэглэхийн эсрэг Олон Улсын конвенц, Дэлхийн допингийн эсрэг код, Олон Улсын стандартууд, Допингийн эсрэг үндэсний дүрмийг Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор допингийн эсрэг мэдээлэл, сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх, допингийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн шинжилгээ авах, баталгаажуулах, үр дүнг тооцон ажиллах зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг төлөвлөгөө хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас гаргасан зөвлөмжийн дагуу Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага /МҮДЭБ/-ын дүрмийг шинэчлэн баталсан. Шинэчлэгдэн батлагдсан дүрмийн дагуу “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнд Засгийн газраас 2, Монголын Үндэсний Олимпын хорооноос 2, Үндэсний Паралимпын хорооноос 2, тамирчдын төлөөлөл 1-ээс доошгүй байх ба 6 хүртэлх хараат бус гишүүд багтана гэж заасны дагуу өмнө 5 гишүүнтэй байсан “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг 13 гишүүнтэй болгон өргөтгөн зохион байгуулсан.

Шинэчлэгдэн батлагдсан дүрмийн дагуу Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, Удирдах зөвлөл болон гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг тусгаарлахаар заасан байна.

Дэлхийн допингийн эсрэг агентлагаас /ДДЭА/ Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагад 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс өмнө биелүүлэх шаардлагатай 21 зүйл залруулах арга хэмжээг авах шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нэн чухал залруулах 11, өндөр ач холбогдолтой 8, ерөнхий 2 залруулах арга хэмжээг 2023 оны 12-р сарын 22-ны өдрийн дотор бүрэн биелүүлснээр Монгол Улсын тамирчид Олимп, Олон улсын уралдаан тэмцээнд цагаан тугийн дор оролцох эрсдэлийг бүрэн арилгасан.



ХОЁР. ҮНДСЭН АЖЛЫН ТАЛААР

Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага нь Дэлхийн допингийн эсрэг агентлагийн шаардлага стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цусны шинжилгээ авах ажлыг эхлүүлж, цусны шинжилгээний хяналтын ажилтан бэлтгэж, ДДЭА-аар итгэмжлэгдсэн лаборатори болох БНСУ-ын допингийн хяналтын лабораторитой хийсэн гэрээг шинэчилж цусны шинжилгээг хийлгүүлэх ажлыг эхлүүлсэн болно.

2023 онд тамирчны биологийн паспорт 13 тамирчнаас авч шинжлүүлсэн бөгөөд цусны шинжилгээнд тавигдах нөхцөлөөс хамааран 2 удаагийн шууд нислэгээр цусны сорьцыг биечлэн хүргэж ажилласан.

Узбекистан Улсын Ташкент хотноо 2023 оны 9-р сард зохион байгуулагдсан Төв Азийн бүсийн допингийн эсрэг байгууллагын /RADOCA/ Удирдах зөвлөлийн хурал болон Үр дүнгийн менежментийн сургалтад Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагын Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал нар оролцож гишүүн орнуудын

допингийн эсрэг байгууллагын төлөвлөгөө, сургалтуудын талаар саналаа солилцож оролцлоо.

Япон улсын Токио хотод 2023 оны 12 дугаар сарын 11-14-ны өдрүүдэд Дэлхийн допингийн эсрэг агентлаг /WADA/, Япон Улсын допингийн эсрэг агентлагийн /JADA/ хамтран зохион байгуулсан боловсролын семинарт МҮДЭБ-ын Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал, гадаад харилцааны албаны дарга нар оролцож цаашдын боловсролын хандлага, төлөвлөлтийн талаар ярилцлаа. Дэлхийн допингийн эсрэг байгууллагын Ерөнхийлөгч, захирлуудтай уулзалт хийж өнөөгийн МҮДЭБ-д тулгараад байгаа нөхцөл байдлын талаар ярилцаж, цаашид хэрхэн ажиллах талаар санал солилцсон.

Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага нь 2023 онд допингийн эсрэг мэдээлэл, сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ сургалтын агуулгад дараах чиглэл, сэдвүүдийг багтаасан болно. Үүнд:

- Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагаас жил бүр гаргадаг “Хориглосон жагсаалт” гэж юу болох, түүний бүтэц, үүрэг, 2023 онд орсон нэмэлт өөрчлөлтүүдийн талаар
- Өөрсдийн хэрэглэж байгаа эм, хүнсний болон биологийн идэвхт нэмэлт бүтээгдэхүүнүүдийг www.globaldro.com сайт болон аппликэйшн рүү орж хэрхэн шалгах
- Эмчилгээний зориулалтаар чөлөөлөгдөх хүсэлтийн зорилго, хэрхэн хаана хүсэлт гаргах талаар
- Допинг, допингийн зөрчлийн тухай ойлголт, допингийн эрүүл мэндэд нөлөөлөх ойрын болон алс ирээдүйд үзүүлэх хор нөлөө, допингоос хэрхэн урьдчилан сэргийлэх
- Шинжилгээний бүртгэлийн санд бүртгэгдсэн тамирчид ADAMS руу яаж нэвтрэх, түүнд байршлын тухай мэдээллээ хэрхэн оруулах, мэдээллийг хэдийд оруулах, хэрхэн засвар хийх болон буруу мэдээлэл оруулснаас болж үүсэх хор холбогдлын талаар

- Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагийн цахим сургалт ADeL (Anti-Doping Education Learning)-д нэвтэрч “Олон улсын хэмжээний тамирчин – Боловсролын хөтөлбөр” судлах, сертификат авах

Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагийн “Олон улсын хэмжээний тамирчин – Боловсролын хөтөлбөр”-ийг Монгол тамирчдад зориулан Монгол хэл дээр орчуулан оруулсан бөгөөд, ингэснээр тамирчид өөрсдөө сургалтын агуулгыг бүхэлд нь уншиж судлах боломжтой болсон.

ADeL e-wada

Welcome to ADeL Dashboard - ADeL Power User > My Courses and Education Programs > Олон улсын хэмжээний тамирчдын хөтөлбөр (ILA_Mongolian)

Олон улсын хэмжээний тамирчдын хөтөлбөр (ILA_Mongolian)
2 courses

0% Education Program Progress
0h 0m | 0h 0m

About this education program

Энэхүү боловсролын хөтөлбөрийн тухай
Энэхүү боловсролын хөтөлбөр нь олон улсын хэмжээний тамирчдад зориулагдсан болно. Үүнд олон улсын хэмжээний тамирчдад зориулсан ДЭСП-ын хичээл, 2021 оны Хуулийн талаарх тамирчдад зориулсан гарын авлага багтсан болно.
Олон улсын хэмжээний тамирчдад зориулсан ДЭСП-ын хичээл нь олон модулийг багтаасан. Модль бүр нь допингийн эсрэг, шударга спорттой холбоотой тодорхой сэдвүүдэд чиглэсэн. Мөн та эцсийн шалгалтад 80%-иас дээш оноо авах шаардлагатай. Эцэст нь санал хүсэлт, цаашдын сайжруулалтын үүднээс танаас суралцсан туршлагын талаарх судалгаа авах болно. Та хичээл болон гарын авлагыг хоёуланг нь дүргэсний дараа гэрчилгээ авах болно.

Олон улсын хэмжээний тамирчдын сургалт (Mongolian)
Олон улсын хэмжээний тамирчдын сургалт Хичээлийн тодорхойлолт Энэ бол олон улсын хэмжээний тамирчдад зайлшгүй шаардлагатай сур...
E-Learning

2021 оны Хуульд гарсан томоохон өөрчлөлтүүдийн талаарх тамирчинд зориулсан гарын авлага
2021 оны Хуульд гарсан томоохон өөрчлөлтүүдийн талаарх тамирчинд зориулсан гарын авлага Энэхүү гарын авлага нь шинэ Хууль 2021-д г...
E-Learning

Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллага нь тайлангийн хугацаанд допингийн эсрэг мэдээлэл, сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх зорилгоор 500 гаруй тамирчин, дасгалжуулагч нарт танхимаар болон онлайн-сургалт зохион байгуулсан.

2023 оны 4 сарын 24-ний өдөр ОБЕГ-ын “Аврагч биеийн тамир, техник-спортын хороо”-той хамтран 15 алба хаагч, тамирчид, дасгалжуулагч нарт допингийн хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион



“МСБХ-ны Хөгжлийн Лиг”-ийн улирлын тоглолтууд эхлэх гэж байгаатай холбогдуулан Монголын сагсан бөмбөгийн холбоо ТББ-тай хамтран 60 гаруй тамирчид, дасгалжуулагч нарт допингийн хор хөнөөл, Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагаас гаргадаг “Хориглосон жагсаалт”-ийн талаар сургалт зохион байгуулав.



Азийн Олимпын Зөвлөлөөс Ханжоу-2022 Азийн наадамд оролцох бүх тамирчдыг Дэлхийн Допингийн Эсрэг Агентлагийн цахим сургалтад хамрагдаж сертификат авсан байх шаардлагыг бүх Олимпын Хороо болон Үндэсний допингийн эсрэг байгууллага руу явуулсан. Үүний хүрээнд Ханжоу-2022 Азийн наадамд оролцох бүх тамирчдад танхимаар болон онлайнаар ДДЭА-ийн цахим сургалт ADeL-д нэвтэрч, “Олон улсын хэмжээний тамирчин – Боловсролын хөтөлбөр” сургалтад хэрхэн хамрагдаж, сертификат авах талаар сургалтыг 2023 оны 8-9 саруудад Ханжоу-2022 Азийн наадамд оролцох 456 тамирчин хамруулан зохион байгуулсан бөгөөд үүнээс 98 тамирчин орон нутгаас болон хилийн чанадаас цахимаар, 358 тамирчин танхимаар хамрагдаж 100% сертификатаа авч тайланг Төв Азийн Бүсийн Допингийн Эсрэг Байгууллага руу явууллаа.

Уг сургалтад бадминтон, байт харваа, бокс, буудлага, волейбол, гандбол, дугуй, жүдо, жү жицү, и-спорт, каное, крикет, кураш, пара байт харваа, сагсан бөмбөг, софт теннис, спорт авиралт, таеквондо, пара таеквондо, теннис, ушу,

хөлбөмбөг, хөнгөн атлетик, хүндийн өргөлт, чөлөөт бөх, шатар зэрэг спортын 37 холбоодын тамирчид хамрагдаж допингийн эсрэг тогтолцооны танилцуулга, дүрэм, допингийн хор хөнөөл, эмчилгээний зорилгоор чөлөөлөгдөх, нэмэлт бүтээгдэхүүн, допингийн шинжилгээний болон байршлын мэдээллийн тухай, допингийн үр дагаврын талаарх мэдээллүүдээр допингийн мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.

Ханжоу-2022 Азийн наадамд оролцсон тамирчдын
допингийн сургалтад хамрагдсан байдал

№	Спортын төрөл	Сургалтад хамрагдсан тамирчдын тоо
1	Бадминтон	13
2	Байт харваа	15
3	Бокс	25
4	Буудлага	15
5	Бүжиг / Брейк	3
6	Волейбол	24
7	Гандбол	9
8	Гимнастик	4
9	Го даам	10
10	Голф	6
11	Дугуй	5
12	Жүдо	15
13	Жү-жицү	16
14	И-спорт	10
15	Каное	1
16	Крикет	23
17	Кураш	6
18	Орчин үеийн 5 төрөлт	1
19	Сагс 3x3	8
20	Сагс	24
21	Скуаш	5
22	Софт теннис	10
23	Спорт авиралт	5
24	Таеквондо	7
25	Теннис	11
26	Триатлон	5
27	Туялзуур сэлэм	8
28	Усанд сэлэлт	29
29	Ушу	2
30	Хөлбөмбөг	44
31	Хөнгөн атлетик	17

32	Хүндийн өргөлт	15
33	Чөлөөт бөх	35
34	Шатар	10
35	Ширээний теннис	10
36	Пара-таеквондо	5
37	Пара-байт харваа	5
	Нийт тамирчдын тоо	456



Допингийн эсрэг мэдээлэл, сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагаа явуулахдаа ашигласан



сургалтын материалууд болон гарын авлага сурталчилгааны материалууд:



Дэлхийн допингийн эсрэг агентлагийн хянан баталгаажуулсан допингийн хяналтын шинжилгээний төлөвлөгөөний дагуу 123 тамирчин, шинжилгээний бүртгэлийн санд бүртгэлтэй 3 тамирчнаас 3 удаа нийт 132 удаагийн допингийн хяналтын шинжилгээ /ДДЭА-н стандартын дагуу нэмэлт тусгай шинжилгээтэй/ мөн Тамирчны биологийн паспорт 13 тамирчдаас авч шинжлүүлсэн.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНД ДЭВШҮҮЛЖ БҮЙ ЗОРИЛТ

1. МҮДЭБ-ийн тогтолцоог олон улсын жишигт хүргэн байгуулж Олон улсын стандартын дагуу үйл ажиллагааг нь хөгжүүлэх

2. БНХАУ, ХБНГУ, Катар улсын допингийн хяналтын лабораториудтай харилцаа тогтоож шинжилгээний зардал, хугацааг бууруулах чиглэлээр хамтран ажиллах.
3. Төв азийн бүсийн допингийн эсрэг байгууллагын 2024 оны Удирдах зөвлөлийн хурал болон сургалтыг Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулах.
4. Допингийн эсрэг сургалт, сурталчилгаа, мөрдөн шалгах, үр дүнгийн менежментэд онцгой анхаарч ажиллах.
5. Үндэсний бөх дах допингийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлж, үр дүнгийн менежментийг авч хэрэгжүүлэх, Дотоодын ADAMs системийг бий болгох чиглэлээр ажиллах.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ДОПИНГИЙН ЭСРЭГ БАЙГУУЛЛАГА